



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 797

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан 14 нэрийн, нийт 5,730,954,416.73 (таван тэрбум долоон зуун гучин сая есөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун арван зургаан төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Өнөболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэн бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, ашиглалтад хүлээн авч, бүртгэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-л үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123007447
37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
797... дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Марк /техникийн тодорхойлолт/	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Нэг цэгийн цогцолбор	26.0x16.0 хэмжээтэй, зoorьтой, 6 давхар оффисын барилга	2023	м2	3126.92	1,555,186.61	4,862,944,104.81
2	Цахилгааны узель	IEK маркын автоматууд, КГ болон ПВ маркын кабель	2023	иж бүрдэл	1	134,963,495.60	134,963,495.60
3	Дотоод сүлжээ	LAN	2023	иж бүрдэл	1	24,893,259.03	24,893,259.03
4	Галын дохиолол	ИП212-141, Рупор-300	2023	иж бүрдэл	1	32,236,158.86	32,236,158.86
5	Нэвтрэх систем	MCDL-DS1000 smart lock	2023	иж бүрдэл	1	8,559,946.17	8,559,946.17
6	Агаар сэлгэлтийн систем	Швед, OSBERG	2023	иж бүрдэл	1	273,943,838.25	273,943,838.25
7	Хөргөлтийн систем	MTCL-9000 BTU	2023	иж бүрдэл	1	131,184,929.99	131,184,929.99
8	Гадна холбооны шугам	12 корын шилэн кабель-70см	2023	иж бүрдэл	1	17,462,080.86	17,462,080.86
9	Гадна цахилгааны шугам	0.4кв-ийн 4x185мм2 кабель 43м	2023	иж бүрдэл	1	25,926,378.49	25,926,378.49
10	Гадна бохирын шугам	Бохир усны хуванцар хоолой 46м	2023	иж бүрдэл	1	7,418,894.10	7,418,894.10
11	Гадна цэвэр усны шугам	Дулааны сувагт ф150, ф100м 40м	2023	иж бүрдэл	1	15,320,856.53	15,320,856.53

12	Гадна дулааны шугам	Угсармал сувагт ф150, ф100м 226м	2023	ИЖ бүрдэл	1	127,908,254.54	127,908,254.54
13	Лифт	IRIS1-PA10 (800) CO60 7/7	2023	ширхэг	1	52,000,000.00	52,000,000.00
14	Явган зам, талбай	Замын хавтан /25x25x25/	2023	м2	150	107,948.13	16,192,219.50
	Нийт дүн						5,730,954,416.73 (таван тэрбум долоон зуун гучин сая есөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун арван зургаан төгрөг далан гурван мөнгө)